ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ

E-NEWSLETTER

facebook.com/Rtcc.m0n
http://rtcc.mrtd.gov.mn
info@rtcc.mrtd.gov.mn
+976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2021 оны 07 дугаар сарын дугаар

"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дүгээр тушаалын 17 дугаар хавсралтаар батлагдсан “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-д заасны дагуу хоног, сарын мэдээг төмөр замын байгууллагуудаас цахим хэлбэрээр тогтмол хүлээн авч мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн 2021 оны 6 дугаар сарын тээвэрлэлтийн мэдээг нэгтгэн боловсруулж албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. 2021 оны 06 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч, ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа, галт тэрэгний зурмагийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, ЗТХЯ-ны www.mrtcc.gov.mn цахим хуудаст инфографик хэлбэрээр байршуулж олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ.

Төвийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас:



Албан хэрэг хөтлөлтийг тоон гарын үсэгт шилжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, токен төхөөрөмжийн ашиглалтыг хэвшүүлэх зорилгоор тоон гарын үсэг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу тоон гарын үсгийн програмыг нийт ажилтнуудын компьютерт суулган, Эйбл албан хэрэг хөтлөлтийн системд тоон гарын үсэг ашиглан албан бичиг, тушаалын төсөл боловсруулж батлуулан ажилласан байна.

ЗТХ-ийн сайдын 2021 оны А/01 дүгээр тушаалаар зам тээврийн салбарын хэмжээнд 2021 оныг “Техник, технологийн шинэчлэлт, цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд “ГТХЗНТ” УТҮГ-ын хариуцсан хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлтийн тайланг 7 дугаар сарын 28 нд цахимаар хүргүүлсэн.

“Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох, санал дүгнэлт гаргах, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх ажлыг хэрэгжүүлэх” ажлын хүрээнд:

Гэрчилгээжүүлэлттэй холбоотойгоор тайлант хугацаанд төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим обьект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх хүсэлтийг 20 аж ахуй нэгж, байгууллага иргүүлсэн.

Хүсэлт иргүүлсэн иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах байдлаар шийдвэрлэгдсэн байна.	
Баримт бичгийн бүрдэл дутуу шалтгаанаар буцаагдсан	9
Ажлын хэсгийн хурлаар дэмжигдсэн	5
Ажлын хэсгийн хурлаар ороход бэлэн болсон	5
Хүсэлт иргүүлсэн, одоогоор хянагдаагүй байгаа	1
Гэрчилгээ олгогдсон	5

Ажлын хэсгийн 1 удаа (07-р сарын 07-ны өдөр)-ийн хурал хуралдсан. 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн №13 тоот хурлаар нийт 13 аж ахуйн нэгжийн гэрчилгээ шинээр олгох болон сунгуулах асуудлыг хэлэлцсэн. Үүнээс:

Шинээр олгохоор шийдвэрлэгдсэн	2
Сунгахаар шийдвэрлэгдсэн	9
Дараагийн хурлаар шийдвэрлэхээр хойшлуулсан	1
Буцаахаар шийдвэрлэгдсэн	1

Тайлант хугацаанд ажлын хэсгийн хурлаар буцаахаар шийдвэрлэсэн 1 аж ахуйн нэгжийн албан бичгийг боловсруулан батлуулж “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-ээр буцаасан. Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/115 дугаар тушаалын дагуу 11 аж ахуй нэгжийн 12 ширхэг гэрчилгээг хэвлэн Төвийн захирлаар баталгаажуулан авч аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн. Гэрчилгээ олгосон хуулийн этгээдүүдийн мэдээллийн нэгдсэн санг 2021 оны 07 дугаар сарын байдлаар хөтлөн ажилласан. Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-д Сайдын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн А/115 дугаар тушаалын дагуу компаниудад олгох дугаар нь системийн алдаанаас үүдэн буруу дугаарлалт олгосныг засварлуулахаар “Лидервишн” ХХК-ийн хариуцсан мэргэжилтэнд 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хүлээлгэн өгсөн. Ажлын хэсгийн чиг үүргийн дагуу иргэн аж, ахуйн нэгжийн хүсэлтийг “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-ээр хүлээн авч, хэрэгжүүлж ажиллаж байна.



“Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:

“Монголиан транс логистик“ ХХК-ын 2021.06.10-ны өдрийн 21/114 тоот албан бичгээр ирсэн хүсэлтийг судлан өөрчлөн тоноглосон 100 вагонд шинээр хяналтын дугаар олгосныг 2021.07.08-ны өдрийн № 242 тоот, “Монцемент билдинг материалс“ ХХК-ын 2021.07.05-ны 3/241 тоот албан бичгээр ирсэн хүсэлтийг судлан 1 зүтгүүрт дугаар олгож 2021.07.23-ны №250 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2021.07.09-ны №245 тоот албан бичгээр "Мосгор транс" ХХК-ын 15 хагас вагоны дугаарыг баталгаажуулсан.

"МТЗ" ТӨХК -ны 5 битүү вагоныг түрээслэгчээр "ЭЙ ТИ ЭМ ТИ" ХХК-г бүртгэн 2021.07.09-ны №246 тоот, “Эвт аян“ ХХК-ын 2021.07.07-ны 004/21 дугаартай албан бичгийг судлан 300 чингэлгийг "ГТХЗНТ" УТҮГ-ын нэгдсэн санд бүртгэснийг мэдэгдэж 2021.07.23-ны №251 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Тайлан

Суурь бүтцийн 2021 оны 6-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

2021 оны 6-р сард нийтдээ 67 удаагийн зурмагийн тасалдал бүртгэгдсэнээс:

Суурь бүтцийн 2021 оны 6-р сарын нийт тасалдлыг 2020 оны мөн үетэй харьцуулан үзэхэд 23 нэгж буюу 22.17% -иар буурсан үзүүлэлттэй байна.

Ковид цар тахал гарсантай холбоотойгоор Улсын Онцгой Коммисын тогтоолоор хот хоорондын зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөнийг тодорхойгүй хугацаагаар зогсоосон.



Тайлан

Суурь бүтцийн 2021 оны 6-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

Ачааны галт тэрэгний явуулалтыг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд 13 нэгж буюу 76.47% -иар буурсан үзүүлэлттэй байна.



Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан үзэхэд тасалдлын тоо 1 нэгж буюу 1.59% -иар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 67 тасалдал үүссэнээс тасалдлыг ангилж үзэхэд зүтгүүрийн гэмтлээс үүдсэн тасалдал хамгийн их буюу 45 тасалдал бүртгэгдсэн байна.



Тайлан

Суурь бүтцийн 2021 оны 6-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

Зүтгүүртэй холбоотой 45 тасалдал гарсан нь нийт тасалдлын 67.16 хувийг эзэлж байна. Графикаас харахад 2ТЭ116УМ серийн зүтгүүр нь хамгийн их буюу 23 (51.11 хувь) нэгж, 2ТЭ25КМ серийн зүтгүүр 9 (20 хувь) нэгж, 2ЗАГАЛ серийн зүтгүүр 3 (6.66 хувь) нэгж, 2ТЭ116УД серийн зүтгүүр 3 (6.66 хувь) нэгж, 2М62ММ серийн зүтгүүр 5 (11.11 хувь) нэгж, М62УМ серийн зүтгүүр 1 (2.22 хувь) нэгж, 2ТЭ-116 серийн зүтгүүр 1 (2.22 хувь) нэгж тасалдал тус тус гарсан байна.



Нийтдээ 67 тасалдал гарснаас хохирлын хэмжээ 11’753’650₮ болсон байна. Үүнийг задалж үзвэл зүтгүүрийн гэмтэл болон зүтгүүрийн гэмтлээс үүдэлтэй хохирлын хэмжээ 9’318’049 төгрөг, технологийн зөрчил буюу ажилчдын буруутай үйлдлээс үүдсэн хохирлын хэмжээ 185’938 төгрөг, төмөр замын гарам, төмөр зам дээр хүн, машин, мал байсан болон дайрагдсанаас шалтгаалан гарсан хохирлын хэмжээ 668’273 төгрөг, сирдп-Е-ийн сүлжээ тасалдлын улмаас үүссэн хохирлын хэмжээ 274’397 төгрөг, бусад буюу үзлэг хийж, байгалийн давагдашгүй хүчин зүйл мөн бусад шалтгаанаар үүссэн хохирлын хэмжээ 1‘306’993 төгрөг болсон байна.



2021 оны 06 дугаар сард өссөн дүнгээр 15930.3 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10.7%-аар өссөн үзүүлэлттэй байна.

ИНФОГРАФИК

Зорчигч тээвэрлэлт /мян.зор/
/өссөн дүнгээр/

	2020он	2021он
Олон улс	9.1	0.00
Орон нутаг	878.6	2.4

Зорчигч эргэлт /сая.зор-км/

2020он	2021он
272.1	2.1

Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/
/өссөн дүнгээр/

2020 /06 сар/	2021 /06 сар/
1940.5 мян.тн	2183.5 мян.тн

Суурь бүтэц эзэмшигчээр /тээвэрлэсэн ачаа/
/өссөн дүнгээр/

Төмрийн хүдэр	Төмрийн хүдэр	Бүх төрлийн ачаа
863.0 мян.тн	2542.2 мян.тн	15930.3 мян.тн

Тээвэрлэсэн ачааны мэдээ /мян.тн/
/өссөн дүнгээр/

	2020	2021
Экспорт	5923.1	5938.6
Импорт	1403.3	1665.5
Дамжин өнгөрөх	1940.6	2183.6
Орон нутаг	5117.5	6142.7

2021 /06 сар/ - 15930.3 мян.тн

Нүүрс	Төмрийн хүдэр	Бусад төрөл ачаа
39.1%	34.2%	2.5%

Галт тэрэгний зурмагийн биелэлт
/өссөн дүнгээр/

Суудал г/т	2020	2021		2020	2021	Ачааны г/т
	2962	0	Өнгөрүүлэлт	23508	25252	
	3061	0	Явуулалт	29891	31807	

Зорчигчийн галт тэрэг явуулалтаар 2020 онд 3088 г/т төлөвлөснөөс 3061г/т явуулж биелэлт 99.1% ,өнгөрүүлэлтээр 3020 г/т төлөвлөснөөс 2962 г/т өнгөрүүлж биелэлт 98.1%, ачааны галт тэрэг явуулалтаар 31864 г/т төлөвлөснөөс 31807 г/т явуулж биелэлт 99.8%, өнгөрүүлэлтээр 25668 г/т төлөвлөснөөс 25252г/т өнгөрүүлж биелэлт 98.4% болсон байна.

СТАТИСТИК

/2021 оны 06 дугаар сарын байдлаар/

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



2021 оны зургаадугаар сард 2547мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



2021 оны зургаадугаар сард 388.7 мян.тн ачаа дамжин өнгөрсөн байна.

Ачилт - ачааны төрлөөр
/2021 оны 06 дугаар сард/



Ачилтаар 2021 оны зургаадугаар сард нүүрс, төмрийн хүдэр, барилгын материал өссөн үзүүлэлттэй байна. Нийт 10.3 мян.тн ачсан байна.

Нүүрс	39.1%
Төмрийн хүдэр	34.2%
Бусад ачаа	2.5%
Барилгын материал	11.9 %
Жонш	3.2%
Зэс, молибдений баяжмал	2.5%
Нефтийн бүтээгдэхүүн	1.9%

Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс